

Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө

Цаг уур, орчны шинжилгээний газар

2024 оны жилийн эцэс

Д/Д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин, үр дүн	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь
1. Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх								
1		1.1. Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентуудыг а/байгууллагын албан ёсны цахим хуудас; б/сошиал сувгууд; в/дотоод сүлжээ; г/хэвлэл мэдээллийг хэрэгсэл, д/мэдээлэл сурталчилгаа самбар, лед		- Тогтмол шинэчлэн, тогтвортой байршуулсан байх; - Түгээсэн, хүрсэн үр дүнгийн талаар салбар хариуцсан ажилтанд тухай бүрт тайлагнадаг байх; - Харьяа нэгжүүдийг нэгэн зэрэг хамруулж, үр дүнг нэгтгэн тайлагнаж хэвших; -			АТГ-аас ирүүлсэн Авлигыг мэдээлэх утас 110 хөдөлгөөнт баннер, Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг, Авлигатай тэмцэх газарт гомдол мэдээлэл өгөх цахим сайтыг цаг уур орчны шинжилгээний газрын https://namem.gov.mn цахим хуудастай холбон нүүр хэсэгт байршуулсан. Мөн АТГ: Гомдол мэдээлэл хүлээн авах утас видео шторкыг нүүр хэсэгт байршуулсан. Авлигын эсрэг нэгдье постер мэдээллийг Цаг уур, орчны шинжилгээний газрын албаны фэйсбүүк хаягт ковер болгон байршуулсаар байна. Уг фэйсбүүк группт, харьяа байгууллагын хүний нөөцийн фэйсбүүк групп, харьяа байгууллагын хүний нөөцийн дарга нарын фэйсбүүк чатаар АТГ-ын "110 подкаст" 2-ийг, Товш апп танилцуулга видеог, "Авлигын эсрэг таны оролцоо", "Авлигын эсрэг хуулиас", "НАТ танд бэлэг, үйлчилгээ, ашигтай нөхцөл байдал санал болгосон тохиолдолд", "Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах этгээдэд хориглоно" зурагт хуудас, Авлигатай тэмцэх газар 21 аймагт видео, скуре группт ХОМ-ийг хэрхэн үнэн зөв гаргах вэ теле хичээлийг оруулж тус салбарын ХАСХОМ өгдөг 140 албан хаагчид хүргэсэн, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг албан хаагчдад танилцуулж харьяа байгууллагуудад хүргүүлсэн.	100%

		дэлгэц, е/бусад (салбар байгууллагууд) хэлбэрээр сурталчилж, олон нийтэд хүргэх		Тайланд холбогдох нотломжийг хавсаргаж хэвших.		Шударга ёс, хөгжил дэвшилд мэдээллийн самбарт 6 удаа мэдээллийг шинэчилж, цаг үеийн мэдээллийг хүргэсэн. Самбарт байршуулсан мэдээг харьяа байгууллагуудад хүргүүлж салбарын албан хаагчдад хүргэсэн. Харьяа 9 байгууллагуудаас Авлигын эсрэг үйл ажиллагааны 2024 оны тайлан хүлээн авсан. Энэ оноос эхлэн тус газрын харьяа 25 байгууллагын 9 нь байгууллагууд өөрсдийн Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж, биелэлтийг тайлагнаад байна. Цаашид нэмэхээр ажиллаж байна. Хавсралт нийт : 27 Файл : 9 Зураг : 18	
2		1.2. Өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан иргэд, олон нийтэд чиглэсэн соён гэгээрүүлэх нээлттэй хаалганы өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулах		- Өдөрлөгт оролцсон иргэдээс байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой санал хүсэлт авч, түүнд үндэслэн арга хэмжээг хэрэгжүүлсэн байх; - Авлигатай тэмцэх газраас өрнүүлж буй аян, уриалгатай уялдсан байх; - Үр дүнг тооцсон байх.		“Авлигын эсрэг олон улсын өдөр”-ийг тохиолдуулан “Авлигын эсрэг нэгдье 2024 Өмнөговь” frame-ийг 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 09-ны өдрүүдийн хооронд байгуулж, тус төвийн хамт олон нь аянд нэгдэж “#Авлигын #эсрэг #нэгдье-2024 #Өмнөговь” гэсэн хаштаг ашиглан хэрэгжүүлж ажиллалаа. Дорнод аймагт Авлигын эсрэг Нэгдье аяны хүрээнд гарын авлага бэлтгэн “Төрийн албаны нээлттэй хаалганы өдөр”-өөр олон нийтэд түгээн ажилласан. Авлигын эсрэг нэгдье уриалгын дор Дорноговь аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв албан хаагчдаа хамруулсан "Авлигын эсрэг нэгдье" богино хэмжээний контентыг бэлтгэн байгууллагын цахим сайтад байршуулж, цаг агаарын мэдээг хэрэглэгч 349 иргэдэд хүргэсэн. https://www.facebook.com/100068987327099/videos/1542890746254672 Хавсралт : 6 зураг	100%
2. Ил тод байдлыг сайжруулах, хүнд суртал, чирэгдлийн бууруулах, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх							
3		2.2. Авлигаас		- Салбарт бүрт		Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарт үйл ажиллагаа	100%

	урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх	үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагуудын нэгдсэн судалгааг гаргасан байх; - Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ авсан байх; - Үр дүнг тооцож, тайлагнасан байх		явуулж буй төрийн бус байгууллагуудын судалгааг гаргасан. 2024 онд тус газраас зохион байгуулсан худалдан авах ажиллагаанд Ус цаг уурын хөгжлийг дэмжих төв ТББ-аас гишүүн Г.Мөнгөнбаатар, ХУД Яармаг ТББ-аас гишүүн А.Энхсайхан, Сэтгэл зүй судалгаа мэдээллийн төв ТББ С.Эрдэнэтуяа нар оролцсон. Нийт 25-н худалдан авах ажиллагаанд хөндлөнгийн ажиглагчаар оролцсон. Хавсралт : 4 файл	
4	2.3. Төсвийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийн талаарх мэдээллийн	- 2024 онд төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаар иргэд, олон нийтэд тогтмол ойлгомжтой		2024 оны төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтыг 2024 оны 1-р сард шилэн дансны Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, концессын зүйлийн жагсаалтад оруулж олон нийтэд нээлттэй мэдээлсэн. https://info.shilendans.gov.mn/ReportFormSettings/ReportOrganizationData Одоогоор тендэр зарлагдаад явж байна. ТБОНӨХБАҮХАТ хуулийн 47 дугаар зүйлийн 47.4 дэх хэсгийн дагуу тендерийн үнэлгээний хороонд хоёроос доошгүй хөндлөнгийн төлөөлөгч оролцуулж, хөндлөнгийн хяналт тавих нөхцөл боломжийг бүрдүүлсэн. Тендэрийн үнэлгээний хороонд Цаг уурын хөгжлийг	100%

	нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангах	байдлаар тогтмол мэдээлэх; - Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилттэй холбоотой иргэд, олон нийтийн саналыг авч, холбогдох арга хэмжээг авах; - Иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ хэрэгжүүлэх.		дэмжих ТББ-ын гишүүн Г.Мөнгөнбаатар, Сэтгэл зүй, судалгаа мэдээллийн төвТББ-ын гишүүн С.Эрдэнэтуяа, ХУД Яармаг ТББ-аас гишүүн А.Энхсайхан нар оролцож хөндлөнгийн хяналтыг тавьж ажилласан. 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2024 оны 1-р сард Шилэн дансны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө-нд оруулж олон нийтэд нээлттэй мэдээлсэн. Нийт 30 байгууллага, 1 хжвь хүнтэй хамтарч ажилласан.	
5	2.4. Байгууллагуудын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой ирүүлсэн гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ	- Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой гомдол, мэдээллийн судалгааг тогтмол гаргаж, тайлагнах; - Хуулийн		Хавсралт нийт : 16 Файл : 15 Зураг : 1	
				Цаг уур, орчны шинжилгээний газарт 2024 онд нийт 3 санал, 34 гомдол ирсэн бөгөөд үүнээс 32 нь Иргэд олон нийттэй харилцах 11-11 төвд, 3 нь цаасаар биечлэн ирүүлсэн. 32 гомдлын 24 нь Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын албан хаагчдад төрийн алба хаасан хугацааны 5 жилийн мөнгөн урамшуулал олгох тухай гомдол байсан. Үүнтэй холбоотой судалгааг хийж, салбарын сайдад албан бичиг хүргүүлсэн. 3 нь тус газрын харьяа Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторийн багаж баталгаажуулах үнэ трифын тухай байсан. Үүний мөрөөр цаг уур, орчны шинжилгээний газрын харьяа Байгаль орчин, хэмжил зүйн төв лаборатори нь Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжүүдэд засвар үйлчилгээ, шалгалт	100%

		хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлж хэвших		хүрээнд шуурхай, бодитой шийдвэрлэж хэвших; - Иргэд, олон нийтээс Байгууллагын үйл ажиллагаа, хүнд суртал чирэгдэл, холбоотой гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлэх.		тохируулга, баталгаажуулалт хийх үүрэг бүхий байгууллага бөгөөд Стандарт Хэмжил Зүйн Газарт агаарын чийг, агаарын даралт, агаарын температур хэмжих тусгайлсан лаборатори байхгүй тул Хэмжил зүйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 10.3, 10.4, 10.5 дугаар заалтын дагуу иргэд, аж ахуй нэгж, байгууллагын хүсэлтээр агаарын чийг, даралт, температур хэмжих хэрэгслийн баталгаажуулалтыг хийж гүйцэтгэдэг болно. Үнэ тарифын асуудлыг Шадар сайдын Ажлын алба болон Стандарт Хэмжил Зүйн Газар шийддэг, Хэмжих хэрэгслийн шалгалт, тохируулга, баталгаажуулалтыг хийхдээ Шадар сайдын 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 10 дугаар тушаалаар баталсан үнэ, тарифыг мөрддөг тул уг асуудлаар Шадар сайдын Ажлын алба болон Стандарт Хэмжил Зүйн Газарт хандахыг зөвлөсөн. Тус газрын харьяа Улаанбаатар хотын УЦУОШТ-ийн үйл ажиллагаатай холбоотой 1 гомдол ирснийг гомдлын дагуу судалж, гомдол гаргагчтай уулзан нэмэлт тайлбар авч гомдлыг барагдуулсан. УБ хотын УЦУОШТ-д цаашид иймкөрчил гаргахгүй байхыг хатуу сануулсан. 11-11 төвд Байгаль орчин, хэмжил зүйн төв лабораторийн үйл ажиллагаатай холбоотой иргэний гомдлыг лабораторийн захирал Б.Цацрал албан хаагчдаа сануулж арга хэмжээ авсан. Хавсралт : 5 файл	
3. Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах							
6		3.1. Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр тухайн байгууллагаас цахимаар иргэд, олон		- Нэвтрүүлсэн цахим үйлчилгээний чанар хүртээмжийн талаар иргэд, олон нийтээс судалгаа, санал асуулга авах; - Дүн	20 сая	Цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийн улмаас эд материалаараа хохирсон, цаг агаарын тодорхойлолт авсан 24 хэрэглэгчээс санал асуулга авсан. Үүний 8 хэрэглэгч цаг агаарын мэдээг аваагүй, аюултай үзэгдэл болохыг мэдээгүй замд гарсны улмаас хохирол амссан гэсэн бол 16 хэрэглэгч цаг агаарын мэдээг авсан боловч яаралтай ажилтай байсан /өвчтэй хүн эмнэлэг уруу авч явах, буяны ажил, гадагшаа нисэх хугацаа болсон, онцгой байдал зам хаагүй тул гайгүй гэж бодсон, цаг агаарын аюултай мэдээ зарлах үед цаг агаар сайхан байсан тул ноцтой хүлээж аваагүй/. И-Монгол академтай хамтран тус	100%

	нийтэд үзүүлж буй цахим үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр арга хэмжээг зохион байгуулах		шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлэх; - Хэрэгжилтийг тайлагнах.		байгууллагийн гар утсанд суурилсан E-mongolia 4.0 шинэчилсэн хувилбарт цаг агаарын урьдчилсан мэдээ болон голуудын үерийн түвшний мэдээллийг оруулан өгч тус аппликейшнийг хэрэглэгч 1.8 сая хэрэглэгчдэд мэдээллийг хүргэж эхлээд байна. Санхүүгийн мэдээллийн технологийн төв УТҮГ-тай хамтран Засгийн газрын хуралдааны цахим систем E-cabinet –д ЦУОШГ-ийн хуудас шинээр нэмж хөгжүүлэлтийг хийж, Засгийн газрын гишүүдэд мэдээллийг тогтмол хүргэх ажлыг хамтран зохион байгуулж нэвтрүүлээд байна. Сансарын хиймэл дагуулаар телевизийн олон сувгийг Монгол орон даяар дамжуулагч ДДэш ТВ ХХК хамтран тус газраас шинээр нэвтрүүлж байгаа шинэ системд цаг агаарын богино хугацааны урьдчилсан мэдээ болон цаг агаарын аюултай үзэгдлийн урьдчилсан мэдээг дамжуулан хүргэх ажлыг хамтран хэрэгжүүлж байна. Шинэ системийг 300 мянган хэрэглэгч ашиглах бөгөөд дийлэх хувийг малчид эзлэж байгаа нь цаг агаарын аюултай үзэгдлийн мэдээллийг малчдад шуурхай хүргэж, эртнээс сэрэмжлүүлэн ажиллахад чухал ажил болно гэж төлөвлөн ажиллаж байна. Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ-тай цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийн мэдээллийг гар утсанд суурилсан аппликейшнээр дамжуулах чиглэлээр хамтран ажиллаж байна . Хавсралт : 3 файл	
7	3.2. Байгууллагын дотоод хяналтын механизмыг сайжруулж, албан хаагчдыг авлига, ашиг сонирхлоос ангид байхад чиглэсэн арга хэмжээг		- Албан хаагчидтай холбогдуулан ирүүлсэн авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг Авлигатай тэмцэх газарт		Албан хаагчдаас авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой гомдол, мэдээлэл ирээгүй байна. АТГ-аас тус газрын 2 томилгоотой холбоотой 2 гомдол ирсэн тул хяналт шалгалт ирж хийсэн. Хяналт шалгалтаар зөрчилгүй болох нь тогтоогдсон. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын 26 байгууллагын 2024 оны Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд улирал бүр дотоод хяналт шинжилгээ хийж зөвлөмж хүргүүлсэн. “Авлигын эсрэг нэгдье, Үгүй гэж хэлээд өөрчилье” аяны хүрээнд салбарын албан хаагчдын АТГ-т албан бичиг хүргүүлэн захиалагт сургалтыг Авлигатай тэмцэх газартай хамтран зохион байгуулсан 2 удаагийн "Авлигын гэмт хэрэг, Эрүүгийн хуулийн зохицуулалт", "Авлигын хор хөнөөл", "Авлигын гэмт хэрэг" сэдэвт сургалтад	100%

		хэрэгжүүлэх;	шилжүүлж хэвших; - Албан хаагчдыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байхад чиглэсэн арга хэмжээг байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан эрсдэлийг тодорхойлсон байх; - Эрсдэлийг арилгах арга хэмжээнд дотоод хяналтын үйл ажиллагааг зохион байгуулсан байх;		салбарын 25 байгууллагын давхардсан тоогоор 550 гаруй албан хаагч хамрагдсан. АТГ-т албан бичиг хүргүүлэн захиалагт сургалт авсан. Удирдлагын акедимаас Төрийн албан хаагчдад зориулсан “Авлигаас ангид төрийн алба” 28 дэд сэдвийн хүрээнд 24 цагийн цахим сургалтад 50 гаруй албан хаагч хамрагдаж Үнэмлэх авсан. Хавсралт нийт : 23 Файл : 6 Зураг : 17	
8	3.3. Тухайн байгууллага өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан авлигаас урьдчилан сэргийлэх, соён		- Төлөвлөгөөний 1.1-3.2 дахь хэсэгт заасан арга хэмжээтэй агуулгаараа давхцахгүй байх; - Байгууллагын		Өөрийн санаачлагаар тус газрын үйлчилгээний онцлог болох өдөр тутмын цаг агаарын мэдээг иргэдэд хүргэдэг өөрийн байгууллагын гадна байрлах урд талын цаг агаарын мэдээ хүргэдэг ЛЕД дэлгэцээр 11 дүгээр сараас эхлэн Авлигын эсрэг нэгдье. аяны хүрээнд "Үгүй гэж хэлээд өөрчилье", "Аливаа зүйл яагаад дүрэм, журам, стандарттай байдаг талаар та бодож байсан уу?", "АТГ - Авлига, ашиг сонирхолын зөрчил гэж юу вэ?" богино хэмжээний видео бичлэгийг тус бүр 3 өдөр буюу 72 цаг цацсан. "Авлигын эсрэг аянд нэгдье" Цаг уур, орчны	100%

	гэгээрүүлэх чиглэлээр шинээр санал, санаачилга гарган тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэх		үйл ажиллагаа, үзүүлж буй төрийн үйлчилгээний онцлогт тохируулан зохион байгуулсан арга хэмжээний үр дүнг олон нийтэд мэдээлсэн байх; - Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмж, албан бичгийн хэрэгжилтийг хангасан байх; - Үйлчилгээ авдаг, хамтарч ажилладаг, зорилтот бүлэгт урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ, хийсэн өөрчлөлт, хүрсэн үр дүнгийн талаар мэдээлэл		шинжилгээний газар нэгдэж өөрийн авлигын эсрэг видео шторкоо бүтээж, өөрийн цахим хаяг, Facebook групп, youtube-д байршуулан түгээсэн. Мөн Авлигын эсрэг нэгдье хүрээнд "ҮГҮЙ гэж хэлээд ӨӨРЧИЛБЕ" гэсэн өөрийн зурагт хуудсыг хийж цахим хаяг, Facebook групп-ээр түгээсэн. Дорноговь аймгийн УЦУОШТ Авлигын эсрэг нэгдэж өөрийн видео шторкоо бүтээсэн. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу шилэн данс, байгууллагын цахим сайтад мэдээллийг бүрэн байршуулж байна. Зорилтот бүлэг: Хөгжлийн бэрхшээлтэй хүнд цаг агаарын мэдээг хүргэх, ойлгуулах чиглэлээр Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газартай хамтран төлөвлөгөө гарган ажиллаж, Цаг уур, орчны шинжилгээний газраас боловсруулсан дараах контентуудад дохионы орчуулга хэлмэрчтэй болгон түгээсэн. 1. Цаг агаарын мэдээг хэрхэн ойлгох вэ? 2. Цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдэл гэж юу вэ? 3. Дэлхий яагаал цаг уурч хэрэгтэй вэ? Сонсголын бэрхшээлтэй иргэдэд зориулж цаг агаарын аюултай үзэгдлийг "МАСС" мессеж үйлчилгээгээр хүргэж байна. Хавсралт нийт : 5 Файл : 2 Зураг : 3	
--	--	--	---	--	---	--

			хүргэсэн байх.					
--	--	--	----------------	--	--	--	--	--